Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн чадавхийг бэхжүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлсон үр дүн

М.Булгантамир[1], Л.Хоролсүрэн[2], Г.Мягмар[3], А.Номин[4], А.Пүрэвгэрэл[1], Э.Батмандуул[1], Г.Баярбат[1], Т.Ариунтуяа[1] Л.Мөнх-Эрдэнэ[1]*

[1]АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, Эрүүл мэндийн бодлого, удирдлагын тэнхим
[2]АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
[3]АШУҮИС, Мэрэгжил дээшлүүлэх институт
[4]АШУҮИС, Эрдмийн сургууль
Цахим шуудан: bulgantamir75.m@gmail.com, Утас: 99829317

Түлхүүр үг:
Эрүүл мэндийн анхан шатны тусламж
Үйлчилгээ
Менежментийн мэдлэгийн түвшин
Сургалтын хэрэгцээ

Товч утга:
Үндэслэл: Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй хүргэхэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагын удирдлага, эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийг сайжруулах суурь шинэчлэлийн үйл явц зайлшгүй шаардлагатай байгааг "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн судалгаа", "Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээ"-ний үр дүн харуулж байгаа нь тус судалгааны ажлын үндэслэл болсон. **Зорилго:** Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн сургалтын хэрэгцээг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн аргыг ашиглан Монгол улсын 4 бүсийн төлөөлөл 4 аймгийн 12 өрх, сумын эрүүл мэндийн төв болон Улаанбаатар хотын 9 дүүргийн 18 өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй нийт 140 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүдийг зорилтот түүврийн аргаар хамруулав. Мэдээллийг тоон болон чанарын аргаар цуглууллаа. Менежментийн сургалтын хэрэгцээг тодорхойлохдоо Хеннесси Хикс-ийн боловсруулсан аргаар сургалтын хэрэгцээг өнөөгийн түвшин болон ач холбогдлын түвшний үнэлгээний зөрүүгээр тодорхойлов. **Үр дүн:** Үнэлгээнд Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн 54 хүн хамрагдсанаас дундажаар 46.5%, орон нутгийн өрх, сумын эрүүл мэндийн 77 хүн хамрагдаж дундаж 38.9% байгаа нь менежмийн талаарх мэдлэг "Хангалтгүй" байгааг илтгэж байлаа. Гэвч менежментийн мэдлэгийн түвшин нь ажилласан жил ахих тусам дээшилж байна. Судалгаанд хамрагдагсдын сургалтын хэрэгцээний үнэлгээ бүгд эерэг утгатай байна. Ач холбогдол болон бодит байдлын түвшин хамгийн их зөрүүтэй үзүүлэлт нь "Гүйцэтгэлийн удирдлага ба хүний нөөц"-ийн талаарх ойлголт байв. **Дүгнэлт:** Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн мэдлэгийн түвшин хангалтгүй, менежментийн сургалтын хэрэгцээ их байна. Менежментийн мэдлэгийн түвшин нь ажилласан жил ахих тусам дээшилж байна.

Үндэслэл: Монгол Улсын эрүүл мэндийн салбар 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн стратегийн нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжин, эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргаар санхүүжүүлж байна. Эрүүл мэндийн салбарт гарч буй суурь шинэчлэлийн үйл явц нь өрх, сумын ЭМТ-үүдийн удирдлага, эмч, мэргэжилтнүүдээс байгууллагыг оновчтой удирдах, зохион байгуулах,

төлөвлөх, хянах, манлайлах менежментийн өндөр мэдлэг, ур чадвартай байхыг зүй ёсоор шаардаж байна. Мөн "ЭМАШТҮ-ний чанар, хүртээмжийн судалгаа, 2020 он", "Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ, 2021 он", "Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээ, 2022 он" зэрэг судалгаануудад ЭМАШТҮ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын менежментийн чадавхийг бэхжүүлэх сургалтын хэрэгцээ өндөр гэсэн үр дүн гарчээ. Өнөөгийн байдлаар өрх, сумын ЭМТ-үүдийн удирдлага, эмч, мэргэжилтнүүдийн менежментийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн системчлэгдсэн, тасралтгүй сургалтын хөтөлбөр болон сургалт байхгүй байгаа нь тус судалгааны ажлын үндэслэл болсон.

Түүнчлэн Сант Люсиагийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн сургалтын хэрэгцээг үнэлсэн судалгаанд оролцогчдын ихэнх нь менежмент, судалгааны арга барилд суралцах нь шаардлагатайг харуулсан байна.[1] Пакистан дахь нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн мэргэжилтэний сургалтын хэрэгцээг үнэлсэн судалгаанд оролцогчдын 75% нь стратеги төлөвлөлтийн чиглэлээр сургалт явуулах шаардлагатай байгааг дурьдсан бол 67.5% нь хүний нөөцийн менежмент, 60% нь багаар ажиллах, санхүүгийн менежмент, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг сэдвүүдээр сургалтын хэрэгцээ шаардлагатай байгааг дурджээ.[2]

Зорилго: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн сургалтын хэрэгцээг үнэлэх.


Зорилт:

1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн талаарх мэдлэгийг үнэлэх.
2. Менежментийн мэдлэгийн түвшинг ажилласан жилтэй харьцуулж үзэх
3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн сургалтын хэрэгцээг судлах.

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн аргыг ашиглан хийж 4 аймгийн 12 өрх, сумын эрүүл мэндийн төв болон Улаанбаатар хотын 9 дүүргийн 18 өрхийн ЭМТ-д ажиллаж буй нийт 140 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, холбогдох мэргэжилтнүүдийг зорилтот түүврийн аргаар хамруулаа. Мэдээллийг тоон болон чанарын аргаар цуглуулсан. Тоон судалгааны аргаар мэдлэг болон хэрэгцээг, чанарын судалгааны аргаар сургалтын хэрэгцээг нарийвчлан үнэллээ. Судалгаанд оролцогчдоос 4 бүлэг бүхий асуумж авлаа. Менежментийн өнөөгийн байдлыг ач холбогдлын түвшингээр, хэрэгжилтийн өнөөгийн бодит түвшингээр 1-5 оноогоор үнэлэв. Өнөөгийн түвшин болон ач холбогдлын түвшний үнэлгээний зөрүүгээр тухайн агуулгын хэрэгцээг тодорхойлсон (Хеннесси Хиксийн сургалтын хэрэгцээг тодорхойлох аргачлал) бөгөөд зөрүүний оноо өндөр байх тусам хэрэгцээ их байна гэж тодорхойлсон. Чанарын судалгааны арга болох зорилтын бүлгийн ярилцлагыг урьдчилан боловсруулагдсан удирдамжийн дагуу зохион байгууллаа. Судалгааны мэдээлэлд STATA16 программуудыг ашиглан боловсруулалт хийв.

Ёс зүйн зөвшөөрөл: Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 2023/3-02 хурлын шийдвэрээр судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан.

Үр дүн: Асуумжид бүрэн хариулсан байдал, хариултын найдвартай байдлын шалгууруар нийт 9 асуумжийг хүчингүйд тооцож, судалгааны үр дүнг 131 асуумжийн хүрээнд боловсруулаа. Судалгаанд оролцогчдын 16% нь эрэгтэй, 84% нь эмэгтэй оролцогчид байв. Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвд ажилласан жилээр авч үзэхэд судалгаанд хамрагдагсдын 5-аас бага жил ажилласан 46%, 6-10 жил 26%, 11-14 жил 0.05%, 15-аас дээш жил ажилласан 21% байв. (Зураг 1)



Зураг 1. Судалгаанд оролцогчдын тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвд ажилласан байдал (жилээр)

Судалгаанд оролцогчдын 21% нь менежментийн ямар нэг сургалтанд хамрагдаж байгаагүй, 46% нь богино болон дунд хугацааны, 15% нь мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байна. (Зураг 2)



Зураг 2. Менежментийн сургалтанд хамрагдсан байдлыг судалсан дүн (хувиар)

Өрх, сумын ЭМТ-ийн удирдлага, эмнэлгийн мэргэжилтнүүдийн менежментийн мэдлэгийн түвшинг үнэлсэн байдлаас тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвд 5-аас бага жил 32.1%, 6-10 жил ажилласан бүлгийхний 21.8% нь, 15-аас дээш жил ажилласан бүлгийхний 25% нь менежментийн мэдлэг муу байсан нь ажилласан жил ахих тусам мэдлэгийн түвшин нэмэгдэж байгаа нь тодорхойлогдлоо. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Менежментийн мэдлэгийг тухайн өрх сумын эрүүл мэндийн төвд ажилласан жилтэй нь харьцуулан судалсан дүн

№	Үнэлгээний түвшин	Тухайн өрх сумын эрүүл мэндийн төвд ажилласан жил (хамрагдсан хүний тоо)				р утга
		<5	6-10	11-14	15<	
1	Маш сайн	0	0	0	0	
2	Сайн	12.5% (7)	12.5% (4)	20% (1)	16.6% (4)	<0.001
3	Дунд	55.3% (31)	65.6% (21)	40% (2)	58.3% (14)	<0.001
4	Муу	32.1% (18)	21.8% (7)	40% (2)	25% (6)	<0.001
5	Хангалтгүй	0	0	0	0	
	Бүгд	**100% (56)**	**100% (32)**	**100% (5)**	**100% (24)**	

Менежментийн сургалтын хэрэгцээг үнэлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын эдгээр үзүүлэлтүүдийн талаарх судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын ач холбогдол болон бодит байдлын зөрүүний шинжилгээ бүгд эерэг утгатай байгаа нь менежментийн хэрэгцээ их байгааг илтгэнэ (Хүснэгт 2). Ач холбогдол болон бодит байдлын түвшин хамгийн их зөрүүтэй байгаа үзүүлэлт нь нийт оролцогчдын хувьд “Гүйцэтгэлийн удирдлага ба хүний нөөц” байсан нь эмнэлгийн мэргэжилтнүүд нь гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог байгууллагад нутагшуулах, ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, гүйцэтгэлийг үнэлэх арга, хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлтийг байгууллагын онцлогт тулгуурлан хийдэггүй зэрэг асуудлууд нь хамгийн дутагдалтай байгааг харуулж байна. Зөрүү хамгийн бага байгаа үзүүлэлт нь “Хяналт” байгаа бөгөөд хэдийгээр энэ үзүүлэлт нь мөн эерэг утгатай ч бусад үзүүлэлтүүдтэйгээ харьцуулбал оролцогчдын хүлээлтэнд дөхсөн байгаа нь тодорхойлогдлоо.

Хүснэгт 2. ЭМАШТҮ-ний ач холбогдол болон бодит байдлыг судалсан дүн (GAP analysis)

д/д	Асуулт	Ач холбогдол		Бодит байдал		Зөрүүний оноо (SNT=CL-LS)
		Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт Хазайлт	
1	Манлайлал	4.72	0.49	3.78	1.05	0.94
2	Төлөвлөлөлт	4.55	0.80	3.73	1.00	0.82
3	Гүйцэтгэлийн удирдлага ба хүний нөөц	4.57	0.77	3.59	0.95	0.98
4	Үйл ажиллагааны зохион байгуулалт	4.46	0.73	3.57	1.00	0.89
5	Ханалт	4.08	0.72	3.66	0.99	0.42
6	Чанар, аюулгүй байдлын менежмент	4.38	0.72	3.48	0.93	0.9
7	Санхүүгийн менежмент	4.49	0.66	3.58	0.98	0.91
8	Мэдээллийн менежмент	4.59	0.60	3.66	0.94	0.93

Хэлцэмж: Бид энэхүү судалгаанд нийт 140 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан, менежментийн мэдлэг, ур чадварыг үнэлж, хэрэгцээг тодорхойллоо. Манай оронд эмч, эмнэлгийн мэргэжилтний менежментийн мэдлэг, хэрэгцээг тодорхойлсон судалгаа байхгүй байна. Бидний судалгаагаар Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн 54 хүн хамрагдаж менежментийн мэдлэгийн дундаж оноо 46.5%, орон нутгийн өрх, сумын ЭМТ-ийн 77 хүн хамрагдаж дундаж оноо 38.9% байлаа.

Менежментийн сургалтын хэрэгцээг үнэлж үзэхэд ач холбогдол болон бодит байдлын зөрүүний шинжилгээ бүгд эерэг утгатай байгаа нь менежментийн хэрэгцээ их байгааг харуулсан бөгөөд хамгийн их зөрүүтэй байгаа үзүүлэлт нь гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, үнэлэх арга, хүний нөөцийн бодлого төлөвлөлт зэрэг асуудлууд нь хамгийн дутагдалтай байгаа нь Хале А (2020) нарын “Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийн мэдлэгийн амжилтанд нөлөөлж буй хүчин зүйлүүд” судалгааны үр дүнгийн хэрэгжилтэд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь мэдээллийн технологи, байгууллагын бүтэц, гүйцэтгэлийн үнэлгээ, хэмжилт зэрэг судлагдсан зэрэг нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байв.[3]

Мөн Ийвий К (2022) нарын “Эрүүл мэндийн менежүүдийн менежментийн ур чадварыг үнэлсэн нь ” судалгааны үр дүн нь менежментийн мэдлэг ур чадварын гол үндэс нь удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн хөгжил, манлайллын зан байдал, мэргэжилтний хандлага зэрэг байсан нь мөн судлаач А.Дүүрэнбилиг 2004-2005 онд “Нийгмийн эрүүл мэндийн зарим мэргэжилтнүүдийн сургалтын хэрэгцээг тодорхойлсон нь” судалгаанд мэргэжилтэнгүүд буюу удирдах ажилтан, статистикч эмч, санхүүжилт хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжлийн ур чадвараа

дээшлүүлэхийн тулд судалгааны арга зүй, эрүүл мэндийн удирдлага, төлөвлөлт, санхүүжилтийн сургалтын хэрэгцээ их гарсан нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байлаа[4,5].

Судалгаа хийх цаг хугацааны болон санхүүжилтийн хязгаарлагдмал байдлаас хамаарч бусад аймаг сумдуудыг судалгаанд хамруулж чадаагүй. Иймд тус судалгаанд бусад аймаг сумдуудыг хамруулах байдал дутмаг байсан нь тус судалгааны ажлын гол хязгаарлагдмал тал юм.

Дүгнэлт:

1. Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн 54 хүн хамрагдаж менежментийн мэдлэгийн дундаж оноо 46.5%, орон нутгийн өрх, сумын ЭМТ-ийн 77 хүн хамрагдаж дундаж оноо 38.9% байгаа нь өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдийн менежментийн мэдлэгийн түвшин хангалтгүй байна.
2. Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвд 5-аас бага жил 32.1%, 6-10 жил ажилласан бүлгийхний 21.8% нь, 15-аас дээш жил ажилласан бүлгийхний 25% нь менежментийн мэдлэг муу байсан нь ажилласан жил ахих тусам мэдлэгийн түвшин нэмэгдэж байгааг харуулж байна.
3. Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүний нөөцийн бодлого төлөвлөлт зэрэг сэдвээр менежментийн сургалтын хэрэгцээ их байна.

Ном зүй:

1. *Janice Gaspard, Che-Ming Yang. Training need assessment of healthcare professionals in a developing country: the example of Saint Lucia. 2016; 16:112. doi: 10.1186/s12909-016-0638-9.*
2. *Sayeeda Amber Sayed. Training need assessment of reproductive health and family planning leaders of leadership development programs in Pakistan Science Journal of Public health. Jan.2015 3(4):538*
3. *Haleh Ayatollahi Kimia Zeraatkar. Factors influencong the success of knowledge management process in health care organisations: a literature review. 2019; doi:10.1111/hir.12285*
4. *Eevi Karsikas, Merja Merilainen, Anna-Maria Tuomiskoski. Health care managers competence in knowledge management: A scoping review. 2022; doi.org/10.1111/jonm.13626*
5. *А.Дүүрэнбилиг. "Нийгмийн эрүүл мэндийн зарим мэргэжилтнүүдийн сургалтын хэрэгцээг тодорхойлсон нь". 2005; х3-4*
6. *ЭМЯ, ДЭМБ, АШУҮИС. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн судалгаа. 2020 он; х19-20*
7. *Эрүүл мэндийн сайдын тушаал " Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийг шинэчлэн батлах тухай" www.moh.gov.mn (2017.01.04)*
8. *Монгол улсын стандарт "Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" 2013, MNS 5081:2013*
9. *М. Энхтөгөлдөр. "Өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын хамт олонд түшиглэсэн сэргээн засах сургалтын хэрэгцээ". 2015; х15-16*
10. *Б.Бадамсэд."Сувилахуйн магистрын хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох нь". 2020; х3*
11. *Хонг Ян. "Өвөр монголын үндэстний их сургуулиар сувилагч бэлтгэж буй сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх хэрэгцээ". 2020; х3-4*
12. *Г.Цэрэн Л.Гантуяа. "Байгууллагын зан төлөв". Улаанбаатар 2006; х3-5*

A research to determine the training needs for strengthening the management capacity of medical professionals in primary health care services

Bulgantamir M[1], Khorolsuren L[2], Myagmar G[3], Nomin A[4], Purevgerel A[1], Batmanduul E[1], Bayarbat G[1], Ariuntuya T [1], Munkh-Erdene L[1]

[1]Department of health policy, School of public health, MNUMS
[2]Institute of public health, MNUMS
[3]Postgraduate training institute, MNUMS
[4]Graduate school, MNUMS
E-mail: bulgantamir75.m@gmail.com, Tel: +976-99829317

Background: The process of fundamental reforms in health sector rightly demands that the provide accessible, high-quality and continuous health care and services to the population. it is necessary to improve the management of the health care providers and the management of medical professionals in the "The quality and access to primary health care service in Mongolia, 2020", "Current situation assessment of primary health care services in Gobisumber aimag showed the results.
Aim: Assessment of management training needs of medical professionals in primary health care services.
Materials and Methods: The survey was conducted by cross sectional method of analytical research on 12 family, soum health center in 4 provinces representing 4 regions of Mongolia, a total of 140 doctors, medical professionals, relevant specialists from the provincial and capital health departments working in soum health center and 18 family health centers in 9 districts of Ulaanbaatar city. Data were collected using quantitative and qualitative methods. When determining management training needs, Hennessy Hicks developed a method to determine training needs based on the difference between the current level and the level of importance.
Results: In the assessment, 54 participants from family health center in Ulaanbaatar took part in an average of 46.5%, and 77 people from soum, family health center in local took part in the average 38.9%, which indicated that the knowledge about management is "insufficient". However, the level of management knowledge is improving as the increase years of work. The assessment of training needs of the respondents is all positive. The indicator with the greatest difference in importance and level of reality was the perception of "Performance Management and Human Resources".
Conclusion: The level of management knowledge of medical professionals in family and soum health centers is insufficient and there is a great need for training. The level of management knowledge is increasing with years of work.

Keywords: Primary health care, Services, Management knowledge level, Training need